



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А103

Есенбулаг

Аймгийн Орон нутгийг судлах музейн
бүтэц орон тоог нэмэгдүүлэн батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12 дахь заалт, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 31 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийг судлах музейн шинэ барилга ашиглалтад орж үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор музейн бүтэц орон тоог хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан орон тоонд багтаан албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталж, 2024 оны төсөвт тусган батлуулж удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг аймгийн Орон нутгийг судлах музейн захирал (Ц.Оюунзул)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2023 оны
01 дугаар сарын 24 өдрийн 1/48 Дугаар
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙГ СУДЛАХ МУЗЕЙН ГТ 20942
БҮТЭЦ ОРОН ТОО

Д/д	Албан тушаал	Батлагдсан орон тоо	Албан тушаалын зэрэглэл
1	Захирал	1	ТҮСБ-6
2	Арга зүйч, боловсролын ажилтан	1	ТҮСБ-4
3	Нягтлан бодогч	1	ТҮ-8
4	Бүртгэл мэдээллийн санч	2	ТҮСБ-4
5	Сан хөмрөгч	1	ТҮСБ-4
6	Эрдэм шинжилгээний ажилтан	2	ТҮСБ-4
7	Тайлбарлагч	2	ТҮСБ-4
8	Дохиолол хяналт, цахим мэдээллийн ажилтан	1	ТҮСБ-3
9	Сэргээн засварлагч, чихмэлчин	1	ТҮСБ-4
10	Зураач, график дизайнер	1	ТҮСБ-2
12	Хүний нөөц, архив бичиг хэргийн эрхлэгч	1	ТҮСБ-1
13	Үйлчилгээний зохион байгуулагч	1	ТҮСБ-2
14	Үзмэр хянагч, арчлан хамгаалагч	2	ТҮСБ-2
15	Сан техникч, цахилгаанчин, мужаан	1	ТҮ-3
16	Нярав-касс	1	ТҮ-2
17	Үйлчлэгч	1	ТҮ-2
18	Гэрээт харуул	4	ТҮ-1
Нийт		24	

